



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№228 /437/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.12.19

Цаг үе, үйл явдал

## Ч.АЛТАНГЭРЭЛ: ПРОФЕССОР БАГШ НАРЫН СУРГАЛТ ТУЙЛЫН СОНИРХОЛТОЙ БАЙВ



юм.

Мөн энэ үеэр "Батлан хамгаалах яамны бодлого, үйл ажиллагаа, Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөлөөс хэрэгжүүлж буй бүтээлч ажлууд" сэдвээр Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчийн Ажлын албаны мэргэжилтэн, Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөлөөс хошууч А.Октябрь нар мэдээлэл хийж, дээрх сургалтыг үр дүнтэй зохион байгууллаа. Мөн тэр бээр цахим нөлөөллийн аяны хүрээнд Батлан хамгаалахын хяналт, шалгалтын нэгжүүдээс улирал тутам зохион байгуулсан "Хандлагаа өөрчилж, хариуцлагаа дээшлүүлье" сэдвэгт сурталчилгааны контентуудыг үзүүлж, албан тушаалтан бүр өөрийн манлайллаа дээшлүүлж, хариуцлагаа нэмэгдүүлэх уриалгыг дэвшүүлсэн юм.

хянан шалгагчийн Ажлын албанаас санаачлан Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүдийг оролцуулсан лекц, мэдээллийг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын бие бүрэлдэхүүнтэй зохион байгуулж буй нь чухал ач холбогдолтой ажил юм. Энэхүү бүтээлч ажил гол төлөв цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчидтай ангид өрнөж байгаа болов уу? Иймд тус ангийн удирдлага хүсэлт гаргаж, хариуцлагаа нэмэгдүүлэн, хандлагаа өөрчлөхөд чиглэгдсэн цуврал сургалтыг өөрийн ангийн бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулж байгаадаа баяртай байна. Мөрдөстэй бүхний бахархал болсон профессор багш нарынхаа лекцийг дахин сонсож байгаадаа баярласнаа илэрхийлье. Профессор багш нарын маань сургалт туйлын сонирхолтой байлаа гэдгийг онцлон тэмдэглэе" хэмээв.

Сургалтын төгсгөлд тус ангийн захирагч хурандаа Ч.Алтангэрэл хэлсэн үгэндээ: "Батлан хамгаалахын Ерөнхий

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын албанаас санаачлан Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүдийн оролцоотойгоор Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын цэргийн алба хаагчид, бие бүрэлдэхүүнд сэтгэл зүй, ёс суртахуун, харилцаа, хандлага, төлөвшилд нь дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн боловсролыг олгох зорилгоор цуврал сургалтуудыг зохион байгуулсаар байна.

ба харилцаа", "Стрессийн удирдлага," "Цагийн менежмент ба хувийн манлайлал" сэдвээр лекц уншиж, офицер, ахлагчийн ёс зүйн харилцаа, хувь хүний манлайлал, байгууллагын соёлын талаар санал солилцлоо. Энэхүү соён гэгээрүүлэх ажлыг Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүн Монгол Улсын гавьяат багш, Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн хүндэт профессор, чөлөөнд байгаа хурандаа А.Гэлэгжамц, ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн тэнхимийн профессор багш С.Мандалмаа нар удирдаж, сонирхолтой арилцлагыг өрнүүлсэн нь онцлог байсан

Тэд энэ удаа Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн захирагч хурандаа Ч.Алтангэрэлийн хүсэлтээр тус ангийн офицер, ахлагч нарт "Зөв хандлага

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-14	-29


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	24

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.452	3.456
EUR	3.672	3.685
CNY	492	495
RUB	51.50	52
JPY	25.45	25.70
KRW	2.64	2.66

### ЗУРХАЙ



2022.12.19 / ДАВАА ГАРАГ /  
БИЛГИЙН ТООЛЛЫН 26

**ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН  
ГАХАЙ САР  
НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ  
УЛААН МОРЬ ӨДӨР**

**Үс засуулбал:**  
**ЖАРГАЛ ҮРГЭЛЖИД ИРНЭ**  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
**08.38-17.01**  
**Барилдлага:**  
Үл зохилдох  
**Шүтэн барилдлага:**  
Мунхрахуй

## ЦЭРГИЙН ДҮРЭМТ ХУВЦАСНЫ ЗӨРЧЛИЙГ АРИЛГУУЛАХ АЖИЛ ОРОН НУТАГТ



Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаал, Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын даргын удирдамжийн дагуу тус аймгийн нутаг дэвсгэрт харуул хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд, худалдаа үйлчилгээний төвүүд, хувь хүн, оёдлын цех, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад энэ сарын 12-13-ний өдрүүдэд хяналт шалгалтын ажлыг явууллаа.

Зөрчил гаргасан хувь хүн, аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 21.3 дахь хэсэгт зааснаар Төрийн алба хаагчийн дүрэмт хувцас, цол, таних тэмдгийг хэрэглэх эрхгүй этгээд хэрэглэсэн бол дүрэмт хувцас, цол, таних тэмдгийг хурааж, 500 нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль оногдуулахыг сануулж, анхааруулж ажиллалаа.



## ХОЛБООЧИН ДАЙЧИДТАЙ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Батлан хамгаалах яамны бодлого, үйл ажиллагааг сурталчлах, бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, ёс суртахуун, харилцаа хандлага, төлөвшилд дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор 12 дугаар сарын 13-ний өдөр Хошууч генерал Р.Гаваагийн нэрэмжит Цэргийн гавьяаны улаан тугийн болон Алтан гадас одонт Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдад сургалт зохион байгуулж явууллаа.

Тус сургалтад гавьяат багш, доктор, профессор, Отгонтэнгэр их сургуулийн багш, чөлөөнд байгаа дэд хурандаа Б.Галиндэв, Төрийн соёрхолт, хүний гавьяат эмч, чөлөөнд байгаа хурандаа Л.Жамбалжав нар

хүрэлцэн ирж "Цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн боловсрол", "Эх оронч үзэл, бахархал, соёрхол", "Батлан хамгаалах яамнаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа болон Иргэний зөвлөлөөс хэрэгжүүлсэн ажил арга хэмжээг алба хаагчдад танилцууллаа.

Мөн энэ үеэр Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчийн ажлын албаны мэргэжилтэн, Батлан хамгаалахын сайдын дэргэдэх иргэний зөвлөлийн нарийн бичгийн дарга, хошууч А.Октябрь "Зөв харилцаа-зөв хандлага" цахим нөлөөллийн аяны талаар бие бүрэлдэхүүнд мэдээлэл өгч, залуу офицер, ахлагч нарыг хандлагаа өөрчилж, хариуцлагаа дээшлүүлэн ажиллахыг уриалсан юм.  
**Хошууч З.АНХБАЯР**



**КОРОНАВИРУС  
ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол

Нийт: 657,826,349

Эдгэрсэн

Нийт: 631,586,337

Нас барсан

Нийт: 6,672,004

Цаг үе, үйл явдал

# ЦЭРГИЙН ГЭРЭЭТ АЛБАНЫ ДАЙЧИД ХИЛИЙН ЧАНАДАД ЭНХИЙГ САХИУЛЖ БАЙНА



Энэ залууг Энхтайваны Отгонболд гэдэг, Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн гэрээт цэргийн алба хаагч. Ховд аймгийн Манхан сумынх. Иргэний цэргийн үүргээ биелүүлж, Зэвсэгт хүчний 032 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж, 2021 онд хүсэл мөрөөдлөөрөө Зэвсэгт хүчний 331 дүгээр ангид үргэлжлүүлэн цэргийн гэрээт алба хааж байгаа түүрүү юм. Тэрээр одоогоор БНӨСУ-д явагдаж байгаа НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний XII ээлжид бусад нөхдийнхөө хамтаар үүрэг гүйцэтгэж байна.

Амралтын цагаараа цэргийн багийнхаа "Хубилай" баазын төв талбайд инээмсэглэн

зогсож буй зургаар хайрт аав, ах, эгч дүүс, анги, хамт олон, онжавууддаа "Би сайн явж ирлээ, албаа сайн хааж байна аа" хэмээн Өмнөд Суданаас мэндчилгээ дэвшүүлжээ.

Цэргийн гэрээт албыг сурлага, сахилгаараа үлгэр жишээ зааж буй залууст энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх боломж дүүрэн байдаг бөгөөд дэд ахлагч Э.Отгонболд шиг олон олон цэргийн гэрээт алба хаагч ажиллагааны газар оронд эх орныхоо даалгаврыг биелүүлж байна. Зарим нь ч нэр төртэйгөөр биелүүлж ирээд удаагүй байна. "Гэрээт цэрэг-Гэрэлтэй алба" гэсний нотолгоо энэ билээ.

Ахмад Д.БОЛОР

## ӨМНИЙН ГОВИЙН БАЙЛДАГЧ НАР ЦОЛ НЭМЖ, НЭГТГЭЛИЙНХЭН АВЬЯАСТНАА ТОДРУУЛАВ



БНМАУ-ын баатар, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагчийн тушаалаар цэргийн сурлага, сахилгаараа бусдыгаа тэргүүлэгч зарим байлдагч нарт ахлах байлдагч, дэд түүрүүц цол олголоо.

Цолыг ангийн удирдлагууд гардуулан өгч "Хугацаат цэргийн алба хаагчид та бүхний байлдагч цол хамгийн сайхан. Байлдагч гэдэг эх орныхоо өмнө тангараг өргөсөн эр хүн бүрийн цол. Харин энэ сайхан цолоо ахиулж түүрүүц болно гэдэг бусдынхаа өмнө хүлээх үүрэг, хариуцлага улам нэмэгдэж байгаагийн илрэл шүү" гээд баяр хүргэсэн юм.

Мөн маршал Х.Чойбалсангийн нэрэмжит Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны Улаан

тугийн одонт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл 2022-2023 оны сургуулийн жилийн "Тэргүүний ардын авьяастан хамт олон" шалгаруулах урлагийн үзлэгийг амжилттай явуулж, дүнгээ гаргалаа. Энэ удаагийн урлагийн авьяастан хамт олноор дэд хурандаа И.Эрдэнэсүрэн даргатай Захиргааны удирдлагын тасаг тэргүүлсэн бол хошууч Ө.Пүрэвжал захирагчтай Танкийн батальон, хошууч А.Ганболд захирагчтай мотобуудлагын батальоны хамт олон удаалав.

Наадмын шилдэг гоцлол дуучнаар ахлагч Э.Батзориг, шилдэг уран уншигчаар дэд ахлагч Т.Буянзаяа, шилдэг бүжгийн хамтлагаар мотобуудлагын батальон, шилдэг язгуур урлагийн төрөлд танкийн батальоны багууд тус тус манлайллаа.

## ЭРДЭНЭТ ХОТЫН ТҮҮХ, ДУРСГАЛЫН ГАЗРУУДАЙ ТАНИЛЦЛАА



БНМАУ-ын маршал Г.Дэмидийн нэрэмжит Байлдааны гавьяаны Улаан тугийн болон Алтангадас одонт Зэвсэгт хүчний 186 дугаар анги Орхон аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран хүүхэд, залуучуудад эх оронч хүмүүжлийг төлөвшүүлэх, түүх соёлоороо бахархах үзлийг түгээн дэлгэрүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгоор цогц ажил, арга хэмжээг хэрэгжүүлсээр байна.

Тухайлбал энэ сарын 15, 16-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчид Эрдэнэт хотын музей болон "Хөх Монгол цогцолбор"-

той танилцлаа. Эрдэнэт хотын музей нь Орхон аймгийн үүсэл хөгжил, түүхэн олдвор, үнэт эдлэл, уул уурхайн ашигт малтмал, монгол аж ахуй, ёс заншил зэргийг харуулсан түүх, дурсгалын арвин их үзвэртэй газар юм.

"Хөх Монгол цогцолбор" хүрээлэнд Монгол Улсын 21 аймгийн нэрийн хуудас болсон үзэсгэлэнт байгаль, сүрлэг хайрхан, уул усны онцлогийг харуулсан баримлууд байдаг бөгөөд Отгонтэнгэр хайрхан, Сэлэнгэ мөрөн, Тайхар чулуу, Сүхбаатарын хөшөөг урласан байдгаараа онцлогтой.

Хошууч О.ОТГОНЦЭЦЭГ

## КОМАНДЛАЛЫН АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТӨВ АНХНЫ СУРАЛЦАГЧДАА АМЖИЛТТАЙ ТӨГСГӨВ



сургагч ахлагч Ч.Батболд (ХЗЦК), сургагч ахлагч Т.Дэлгэрхүү (014) нар сургагч багшаар ажиллаж байна.

Анхны суралцагчдаа амжилттай төгссөн сургагч ахлагч Ч.Батболд сэтгэгдлээ хуваалцахдаа "Сургалт маш амжилттай явагдаж өндөрлөлөө. Суралцагч нар суралцах хүсэл, чармайлт өндөр, сургалтын материаллаг бааз бүрэн хангагдсан байсныг тодотгох ёстой. Англи хэлний дунд шатыг үндсэндээ Хуурай замын цэргийн нэгтгэл, ангийн 15 цэргийн алба хаагч буюу 8 офицер, 7 ахлагч амжилттай төгслөө. Үүнээс өмнө бэлтгэл дунд шатаар төгссөн алба хаагчид ч бий. Бидний сургалтын гол давуу чанар нь Монгол Улс, БНЭУ-ын Зэвсэгт хүчний хамтын ажиллагааны хүрээнд Энэтхэг багш хошууч Ишан Шингал яриа, бичгийн чадварын сургалтыг өнгөрсөн 10 дугаар сараас хамтатган явууллаа. Сургалт ЗХЖШ-ын Гадаад хэлний сургалтын төвийн хөтөлбөр, төлөвлөгөөгөөр явагдсан. Бид дараагийн сургалтаа 2023 оны нэгдүгээр сард эхлүүлнэ" гэлээ.

Ахмад Д.БОЛОР  
Гэрэл зургийг О.МӨНХБАТ


Сургалт

## МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №39

ЖА ҮСГИЙН БҮТЭЦ, ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ  
ЖА бол дэвсгэр бус үсэг. ОЦМХ-ний Ж, З үсгийг монгол бичигт ганц энэ ЖА-гаар тэмдэглэдэг. Учир нь, монгол туургатны аялгуунуудад ЖА, ЗА-г харилцан сэлгэж дууддаг бөгөөд адилхан бичээд, өөр өөрийнхөөрөө унших боломжийг бүрдүүлжээ. Бүтэц зурлагын хувьд, нурууны шугам дээр зартиг буюу толгойтой шилбэ татаад, үзгэ салгаж, доош нуруу татсанаар ЖА үсэг бүтдэг. Үгийн дунд, нуруу татаад үзгэ салган зүүн гар талаас нь дугуй өнцөгтэй "сэрээ" зурлага гаргаж нийлүүлэн бичнэ.

Уншигч та бүхэн үгийн эхэнд, дунд, төгсгөлд ордог ЖА, ЖЭ, ЖИ, ЖО, ЖУ, ЖӨ, ЖҮ гэж аялгуулан дуудаж үе үсэг хэрхэн хувирч буйг нүдлэн тогтоогоорой.

Бичмэл тигээр:



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Англи хэлний сургалтын төв анхны суралцагч офицер, ахлагч нараа төгсгөлөө. Төгсөлтийн арга хэмжээ энэ сарын 9-ний өдөр зохион байгуулагдаж, суралцагч нарт Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, хурандаа Д.Дугаррагчаа баяр хүргэж, гэрчилгээг нь гардуулан өгөв.

Энэ үеэр төгсөгч нар англи хэлээр 1 жилийн хугацаанд явагдсан сургалтын талаарх сэтгэгдлээ илэрхийлж, талархал дэвшүүлж байв.

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал болон АНУ-ын Энэтхэг Номхон далайн Хуурай замын цэргийн командлал хоорондын хамтын ажиллагааны хүрээнд 2021 оны 12 дугаар сард Хуурай замын цэргийн командлал болон Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид иж бүрэн Англи хэлний сургалтын төвүүд байгуулагдсан билээ.

АНУ-ын хөрөнгө оруулалтаар байгуулагдсан энэхүү сургалтын төвүүд үйл ажиллагаагаа Хуурай замын цэргийн командлал, нэгтгэл, ангиудын 40 орчим офицер, ахлагчтайгаар эхлүүлсэн бөгөөд